



ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Эрүүгийн эрх зүйн хэрэг, маргаан¹)

НАС БАРСАН ХҮНИЙ ОРОН БАЙРАНД ХУУЛЬ БУСААР НЭВТЭРЧ ЭД ЗҮЙЛ АВСАН НЬ ОРОН БАЙРНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ МӨН

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 3 StR 526/19

Шүүхийн шийдвэрийн огноо: 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр

Шийдвэрийн төлөв байдал: Муж Улсын шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээн шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч нь 4 удаагийн үйлдлээр орон байрны хулгайн гэмт хэрэг^{2,1} удаагийн үйлдлээр хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хулгайн гэмт хэргийг³ үйлдэхээр завдсан гэх хэрэгт тус тус холбогджээ. Тодруулбал:

- i. Шүүгдэгч нь 2016 оны 06 дугаар сарын 24-ний шөнө бусдын орон байрны цонхыг хагалж хууль бусаар нэвтэрч 490 еврогийн дүнтэй тэнцэх хэмжээний эд зүйл хулгайлсан;
- ii. Шүүгдэгч нь 2017 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Г-тэй хамтран бусдын орон байрны цонхыг хагалж хууль бусаар нэвтэрч 60 евро (бэлнээр) хулгайлсан байна. Тухайн үед шүүгдэгчийн хууль бусаар нэвтэрч орон байрны цор ганц оршин суугч нь хэдэн хоногийн өмнө нас барсан бөгөөд шүүгдэгч энэ талаар өдөр тутмын сонин дээрх эмгэнэл илэрхийлсэн мэдээнээс олж мэдсэн байжээ. Шүүгдэгчийг орон байранд гэмт үйлдлээ үйлдэж байхад Г нь хүн харахаар байшингийн гадна үлдсэн байна.
- iii. Шүүгдэгч 2017 оны 06 дугаар сарын 29-ны шөнө Г-тэй хамтран бусдын орон байрны хаалгыг эвдэн нэвтэрч шүүгээн дотор байсан сейфийг авч явсан бөгөөд хэргийн газраас холдсоны дараа уг сейфийг онгойлгон 1.000 евро (бэлнээр) авсан;
- iv. Шүүгдэгч нь 2017 оны 07 дугаар сарын 19-ны өдөр спорт клубийн агуулахын цоожийг эвдлэн нэвтэрч тоног төхөөрөмж хулгайлсан;

¹ Холбооны Улсын дээд шүүхийн уг шийдвэрийг Juracase.com сайт дээр байршуулсан “Эрүүгийн эрх зүйн шалгалтад зориулсан шилмэл 10 шийдвэр” гэх нийтлэлд тулгуурлан сонгов. Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: https://juris.bundesgerichtshof.de/cgi-bin/rechtsprechung/document.py?Gericht=bgh&Art=en&sid=453d67e68fd02677f9c569c737e503a3&n_r=105630&pos=0&anz=1

² Эрүүгийн хуулийн 244 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт “Гэмт хэрэг үйлдэхдээ орон байрыг эвдэн орсон, түлхүүр эсвэл онгойлгох багаж хэрэгсэл ашиглан нэвтэрсэн эсвэл тухайн орон байранд нуугдаж үлдсэн бол 6 сараас 10 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ”, Цахим холбоос: <https://www.gesetze-im-internet.de/stgb/> [Сүүлд хандсан:2023.05.16]

³ ЭХ-ийн 242 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Бусдын хөдлөх эд хөрөнгийг өөртөө болон гуравдагч этгээдэд хууль бусаар шилжүүлэхийн тулд санаатай авсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ.”



- v. Шүүгдэгч нь 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Г-тэй хамтран эзэмшигч нь нас барсан хүний байшинд дахин очсон бөгөөд цонхоор авирч ороход уг байшинд мөрдөгч байсны улмаас үйлдлээ төгсгөж чадаагүй байна.

ХУУЛИЙН ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. Муж Улсын шүүх (*Landgericht*) нь шүүгдэгчийн *i, ii, iii дахь үйлдлийг орон байрны хулгай* (Эрүүгийн хуулийн 242 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 244 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт), *iv дэх үйлдлийг онц ноцтой хулгай* (Эрүүгийн хуулийн 243 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 болон 3 дахь заалт), *v дахь үйлдлийг орон байрны хулгайн гэмт хэрэгт завдсан* (Эрүүгийн хуулийн 242 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 244 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Эрүүгийн хуулийн 22, 23 дугаар зүйл) гэмт хэргийг тус тус үйлдсэн хэмээн үзэж 3 жил 8 сарын хорих ял оногдуулж, гэмт хэргийн улмаас олсон орлого болон хулгайн эд зүйлийг хураан авахаар шийдвэрлэжээ.
 2. Шүүгдэгч Муж Улсын дээд шүүхийн шийдвэр нь материаллаг хууль зөрчсөн үндэслэлээр хяналтын гомдол гаргасан байна.
 3. Холбооны Улсын дээд шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хянаад *нас барсан хүний үл хөдлөх хөрөнгө нь Эрүүгийн хуулийн 244 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан орон байранд хамаарна*. Орон байрны цор ганц оршин суугч нас барснаас хойш гэмт хэрэг үйлдэгдэх цаг мөчид байшин эзэнгүй байсан ч гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангаж байна хэмээн Муж Улсын шүүх (*Landgericht*) үзсэн нь хууль зүйн үндэслэлтэй байна.
 4. *Орон байр гэж ядаж л түр хугацаагаар амьдрах зориулалттай цоожтой болон дээвэртэй өрөөг хэлнэ*. Шүүгдэгчийн хууль бусаар нэвтэрч орсон байшингууд нь тохижуулсан мөн орон сууцаар ашиглах бүрэн боломжтой байжээ.
 5. Эрүүгийн хуульд “Орон сууц” хэмээх ойлголтыг:
 - Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлийн 1(Орон байрны амгалан тайван байдал алдагдуулах),
 - Эрүүгийн хуулийн 201а дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-т (Зураг авах байдлаар бусдын орон зайд халдах),
 - 306а дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 1 (Аюултай аргаар галдан шатаах) дахь заалтад тус тус тусгасан байна.
- Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлийн 1 болон 201а дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт нь тухайн гэмт хэрэг үйлдэх үед орон байранд оршин суугч байсан байх об'ектив шинжийг шаардахгүй бол Эрүүгийн хуулийн 306а дугаар зүйлд заасан аюултай аргаар галдан шатаах гэмт хэргийн об'ектив шинж нь гэмт хэрэг үйлдэх үед тухайн орон байранд оршин суугч нь байсан байхыг шаарддаг байна. Харин орон байрны хулгайн гэмт хэргийн хувьд гэмт хэрэг үйлдэгдэх цаг хугацаанд тухайн орон байранд оршин суугч нь байхыг шаардахгүй болно.
6. Эрүүгийн хуулийн 244 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын зорилгоос авч үзвэл эзэнгүй үл хөдлөх хөрөнгө нь орон сууцад хамаарна. Энэхүү зохицуулалт нь хувийн өмчийг хамгаалах, орон байрны бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилготой болно.

Орчуулсан: Э.Баасанбямба

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн

Эрүүгийн эрх зүйн судлаач